

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Балжинням  
Утас: 70432545  
цахим хаяг: baljinyam.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

|  |    |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                  | 3  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                           | 3  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                        | 3  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....             | 5  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                         | 7  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                  | 8  |
| 3. Аудитын тайлан.....   | 8  |
| 3.1 Ерөнхий зүйл.....  | 8  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 9  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                            | 9  |
| 3.4 Материаллаг байдал .....   | 9  |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 10 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                        | 10 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                  | 11 |
| 3.8 Аудитын гол асуудал .....  | 11 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 11 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....                            | 11 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                       | 11 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 11 |
| 4. Аудитын илрүүлэлт .....   | 11 |
| 4.1 Залруулсан алдаа.....  | 11 |
| 4.3 Зөвлөмж .....  | 12 |
| 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....                         | 12 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| НА       | Нотлох ажил   |



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
АЛБАНЫ ДАРГА Б.МӨНХБААТАР  
ТАНАА**

2022.02.10. № 2/16.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



321020067

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>5,562,000.00</b>   | <b>5,549,500.00</b>   |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 5,562,000.00          | 5,549,500.00          |
| <b>351</b> | <b>Түүхий эд материал</b>   | 1,335,000.00          | 549,500.00            |
| 35130      | Эм боох материал  | 1,335,000.00          | 549,500.00            |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 4,227,000.00          | 5,000,000.00          |
| 35420      | Аж ахуйн материал   | 127,000.00            | 220,000.00            |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 4,000,000.00          | 4,780,000.00          |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>224,142,732.47</b> | <b>312,443,159.13</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 224,142,732.47        | 312,443,159.13        |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 197,322,732.47        | 285,623,159.13        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 151,814,970.00        | 188,262,221.86        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | -11,966,536.08        | -18,887,227.82        |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 40,715,000.00         | 40,715,000.00         |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | -20,317,153.07        | -27,102,986.43        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 73,269,927.74         | 73,889,727.74         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -60,355,184.00        | -64,689,297.78        |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 4,199,214.29          | 4,199,214.29          |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -2,148,950.86         | -2,460,452.58         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 26,275,700.00         | 26,275,700.00         |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | -4,164,255.55         | -5,060,404.15         |
| 39216      | Дуусаагүй барилга, байгууламж   | 00.00                 | 70,481,664.00         |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 26,820,000.00         | 26,820,000.00         |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 26,820,000.00         | 26,820,000.00         |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>229,704,732.47</b> | <b>317,992,659.13</b> |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>229,704,732.47</b> | <b>317,992,659.13</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 229,704,732.47        | 317,992,659.13        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 61,261,783.00         | 61,261,783.00         |
| 51101      | Өмч: - төрийн   | 34,441,783.00         | 34,441,783.00         |
| 51106      | Эздийн өмчийн бусад хэсэг   | 26,820,000.00         | 26,820,000.00         |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 77,906,938.72         | 166,194,865.38        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 77,906,938.72         | 77,906,938.72         |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 00.00                 | 88,287,926.66         |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 90,536,010.75         | 90,536,010.75         |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>229,704,732.47</b> | <b>317,992,659.13</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт                               | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b> | <b>252,465,586.95</b> | <b>384,109,615.86</b> |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>             | <b>18,417,986.95</b>  | <b>40,744,651.86</b>  |

|             |   |                       |                       |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 18,417,986.95         | 40,744,651.86         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 18,417,986.95         | 40,744,651.86         |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 9,409,000.00          | 4,297,400.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 9,008,986.95          | 36,447,251.86         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>229,547,600.00</b> | <b>343,364,964.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 229,547,600.00        | 267,035,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 229,547,600.00        | 267,035,100.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 00.00                 | 76,329,864.00         |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 72,981,664.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 00.00                 | 3,348,200.00          |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>260,502,565.88</b> | <b>295,821,689.20</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>260,502,565.88</b> | <b>295,821,689.20</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 259,810,565.88        | 295,524,289.20        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 200,116,960.00        | 232,226,700.00        |
| 210101      | Үндсэн цалин  | 101,470,960.00        | 133,378,800.00        |
| 210102      | Нэмэгдэл  | 82,110,000.00         | 79,767,900.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 16,536,000.00         | 19,080,000.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 7,550,000.00          | 5,070,900.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 5,550,000.00          | 5,070,900.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | 8,942,623.00          | 5,767,500.00          |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,145,532.00          | 1,784,636.00          |
| 210302      | Түлш, халаалт   | 6,020,091.00          | 2,405,752.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 1,777,000.00          | 1,577,112.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 16,237,303.00         | 16,256,200.00         |
| 210401      | Бичиг хэрэг   | 2,458,803.00          | 2,636,200.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 11,362,400.00         | 10,100,000.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 1,289,600.00          | 1,300,000.00          |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | 481,700.00            | 420,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 644,800.00            | 1,800,000.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 4,237,950.00          | 4,136,300.00          |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 4,237,950.00          | 4,136,300.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 564,700.00            | 4,578,400.00          |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл  | 444,700.00            | 450,000.00            |
| 210604      | Урсгал засвар   | 120,000.00            | 4,128,400.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | 2,844,300.00          | 3,000,000.00          |
| 210702      | Дотоод албан томилолт   | 2,844,300.00          | 3,000,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 1,328,689.00          | 5,240,000.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 518,600.00            | 4,600,000.00          |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 330,000.00            | 330,000.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 170,089.00            | 150,000.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо   | 60,000.00             | 60,000.00             |
| 210807      | Газрын төлбөр   | 100,000.00            | 100,000.00            |

|             |  |                      |                      |
|-------------|--|----------------------|----------------------|
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>             | 17,988,040.88        | 19,248,289.20        |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                 | 17,988,040.88        | 19,248,289.20        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                            | 692,000.00           | 297,400.00           |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b> | 692,000.00           | 297,400.00           |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                              | 692,000.00           | 297,400.00           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>          | <b>-8,036,978.93</b> | <b>88,287,926.66</b> |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                     | <b>-8,171,912.37</b> | <b>88,287,926.66</b> |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн     | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 61,261,783.00                   | 90,536,010.75         | 85,028,908.09         | 236,826,701.84                         |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>61,261,783.00</b>            | <b>90,536,010.75</b>  | <b>85,028,908.09</b>  | 236,826,701.84                         |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | -8,171,912.37         | -8,171,912.37                          |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>61,261,783.00</b>            | <b>90,536,010.75</b>  | <b>77,906,938.72</b>  | 229,704,732.47                         |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>61,261,783.00</b>            | <b>90,536,010.75</b>  | <b>77,906,938.72</b>  | 229,704,732.47                         |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>61,261,783.00</b>            | <b>90,536,010.75</b>  | <b>77,906,938.72</b>  | 229,704,732.47                         |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 88,287,926.66         | 88,287,926.66                          |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>61,261,783.00</b>            | <b>90,536,010.75</b>  | <b>166,194,865.38</b> | 317,992,659.13                         |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>   | <b>243,456,600.00</b> | <b>347,662,364.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>9,409,000.00</b>   | <b>4,297,400.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 9,409,000.00          | 4,297,400.00          |
| 120004      | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>   | 9,409,000.00          | 4,297,400.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 9,409,000.00          | 4,297,400.00          |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>234,047,600.00</b> | <b>343,364,964.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 229,547,600.00        | 267,035,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 229,547,600.00        | 267,035,100.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 00.00                 | 76,329,864.00         |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 72,981,664.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 00.00                 | 3,348,200.00          |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>  | <b>243,456,600.00</b> | <b>277,180,700.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>243,456,600.00</b> | <b>277,180,700.00</b> |

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                     | <b>242,764,600.00</b> | <b>276,883,300.00</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                   | 198,646,000.00        | 232,226,700.00        |
| 210101      | Үндсэн цалин   | 99,973,332.00         | 133,378,800.00        |
| 210102      | Нэмэгдэл   | 82,136,668.00         | 79,767,900.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 16,536,000.00         | 19,080,000.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                      | 7,550,000.00          | 5,070,900.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 5,550,000.00          | 5,070,900.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                           | 8,322,500.00          | 5,767,500.00          |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 1,098,500.00          | 2,298,500.00          |
| 210302      | Түлш, халаалт  | 5,447,000.00          | 1,969,000.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 1,777,000.00          | 1,500,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                    | 15,258,100.00         | 15,680,000.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 1,463,400.00          | 2,000,000.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 11,362,400.00         | 10,100,000.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,305,800.00          | 1,300,000.00          |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                  | 481,700.00            | 480,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                | 644,800.00            | 1,800,000.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 4,270,400.00          | 3,700,000.00          |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 4,270,400.00          | 3,700,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                   | 4,564,700.00          | 6,198,200.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 4,000,000.00          | 1,619,800.00          |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 444,700.00            | 450,000.00            |
| 210604      | Урсгал засвар  | 120,000.00            | 4,128,400.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 2,844,300.00          | 3,000,000.00          |
| 210702      | Дотоод албан томилолт  | 2,844,300.00          | 3,000,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>            | 1,308,600.00          | 5,240,000.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж       | 518,600.00            | 4,600,000.00          |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 330,000.00            | 330,000.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 150,000.00            | 150,000.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 60,000.00             | 60,000.00             |
| 210807      | Газрын төлбөр  | 100,000.00            | 100,000.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>692,000.00</b>     | <b>297,400.00</b>     |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                         | 692,000.00            | 297,400.00            |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 692,000.00            | 297,400.00            |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b>00.00</b>          | <b>70,481,664.00</b>  |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>00.00</b>          | <b>70,481,664.00</b>  |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>00.00</b>          | <b>70,481,664.00</b>  |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | 00.00                 | 70,481,664.00         |
| 220001      | Барилга байгууламж   | 00.00                 | 70,481,664.00         |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b>00.00</b>          | <b>-70,481,664.00</b> |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                |
|-----------------------|--|-----------------------|----------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 271,035,100.00        | 271,035,100.00 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 271,035,100.00        | 271,035,100.00 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 271,035,100.00        | 271,035,100.00 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 232,226,700.00        | 232,226,700.00 |
| 210101                | Үндсэн цалин   | 133,378,800.00        | 133,378,800.00 |
| 210102                | Нэмэгдэл   | 79,767,900.00         | 79,767,900.00  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт  | 19,080,000.00         | 19,080,000.00  |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 5,070,900.00          | 5,070,900.00   |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 5,070,900.00          | 5,070,900.00   |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 5,767,500.00          | 5,767,500.00   |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 2,298,500.00          | 2,298,500.00   |
| 210302                | Түлш, халаалт  | 1,969,000.00          | 1,969,000.00   |
| 210303                | Цэвэр, бохир ус  | 1,500,000.00          | 1,500,000.00   |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 15,580,000.00         | 15,580,000.00  |
| 210401                | Бичиг хэрэг  | 2,000,000.00          | 2,000,000.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 10,000,000.00         | 10,000,000.00  |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,300,000.00          | 1,300,000.00   |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 480,000.00            | 480,000.00     |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,800,000.00          | 1,800,000.00   |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>  | 3,700,000.00          | 3,700,000.00   |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 3,700,000.00          | 3,700,000.00   |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 450,000.00            | 450,000.00     |
| 210603                | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 450,000.00            | 450,000.00     |
| <b>2107</b>           | <b>Томилолт, зочны зардал</b>  | 3,000,000.00          | 3,000,000.00   |
| 210702                | Дотоод албан томилолт  | 3,000,000.00          | 3,000,000.00   |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 5,240,000.00          | 5,240,000.00   |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,600,000.00          | 4,600,000.00   |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 330,000.00            | 330,000.00     |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар   | 150,000.00            | 150,000.00     |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 60,000.00             | 60,000.00      |
| 210807                | Газрын төлбөр  | 100,000.00            | 100,000.00     |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 271,035,100.00        | 271,035,100.00 |
| <b>1310</b>           | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | 267,035,100.00        | 267,035,100.00 |
| 131001                | Улсын төсвөөс санхүүжих  | 267,035,100.00        | 267,035,100.00 |
| <b>120004</b>         | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | 4,000,000.00          | 4,000,000.00   |
| 1200041               | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 4,000,000.00          | 4,000,000.00   |
| <b>62</b>             | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | 14.00                 | 14.00          |

|        |                   |       |       |
|--------|-------------------|-------|-------|
| 620001 | Удирдах ажилтан   | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан   | 01.00 | 01.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан төгрөгөөр

| Дансны код  | Үзүүлэлт  | Гүйцэтгэл            |
|-------------|---|----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>76,329,864.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>5,848,200.00</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 5,848,200.00         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 100,000.00           |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 100,000.00           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 5,748,200.00         |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 1,619,800.00         |
| 210604      | Урсгал засвар   | 4,128,400.00         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>70,481,664.00</b> |
| 2200        | Дотоод эх үүсвэрээр   | 70,481,664.00        |
| 220001      | Барилга байгууламж  | 70,481,664.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | 76,329,864.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 76,329,864.00        |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,981,664.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 3,348,200.00         |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд худалдан авсан бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа N баримтаар баталгаажуулаагүй, ажилчдад олгосон цалингийн тооцооны картад гарын үсэг зуруулж баталгаажуулаагүйтэй холбоотой зөвлөмжүүдийг өгсөн болно.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 02 дугаар сарын 07-ноос 2022 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 015/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь “Шинжлэх ухааны тодорхой салбарыг шинжилгээ судалгааны арга барилд түшиглэн өндөр технологи бүхий лабораторийн техник хэрэгсэл ашиглан бодит баримт материалуудад шинжилгээ хийж, хуулийн шаардлагын дагуу үнэн зөв хууль зүйн үндэслэл бүхий хариу, дүгнэлт магадалгаа гарган өгөх, мэдлэг чадвартай шударга, зарчимч, хүнлэг, ёс зүйтэй мэргэшсэн алба хаагчдыг үр дүнтэй тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж байгууллагын эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд эрүү иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэх, эрх бүхий этгээдүүдээс илрүүлсэн тогтоол шийдвэрийг үндэслэн шинжилгээ хийж дүгнэлт гаргах эрх бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо ХЗДХ яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 323,094.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3,230.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,584.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,548.7 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 323,094.8 мянган төгрөг, оны эцэст 430,643.5 мянган төгрөг болж 107,548.7 мянган төгрөгөөр өссөн нь дуусаагүй барилга 70,481.6 мянган төгрөг, өөрийн хөрөнгөөр 619.9 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын балансаас 36,447.2 мянган төгрөгийн үнэтэй орон сууц шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн дансны оны эхний үлдэгдэл 229,704.7 мянган төгрөг байсан оны эцэст 317,911.6 мянган төгрөг болж тайлант онд 88,287.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн дансны нөлөөлөл байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 76,329.8 мянган төгрөг төвлөрснөөс Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 70,481.0 мянган төгрөг, ИТХ-аас сургалт сурталчилгааны зардалд 2,500 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,348.8 мянган төгрөгийн санхүүжилт орж, батлагдсан арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 271,035.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 271,035.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас тус байгууллагын төсвийг 271,035.1 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 271,035.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 271,035.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 267,035.1 мянган төгрөгийн, өөрийн үйл ажиллагаанаас 4,297.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 271,035.1 мянган төгрөгийг зарцуулж 297,4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 17, зарлагын 2 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 10,587.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,747.3 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,850.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өртгөө бүрэн элэгдүүлээгүй үндсэн хөрөнгийг байгууллага хооронд шилжүүлэхдээ журналын бичилт буруу хийгдсэн, тайлант оны үр дүн данс буруу илэрхийлэгдсэн алдаа зөрчил илэрлээ.

2. **Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 8,747.3 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа N баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг N баримтаар баталгаажуулан ажиллах.

##### 2. Анхан шатны баримтын бүрдүүлэлт

**2.1. Илрүүлэлт:** Тайлант онд ажилчдад олгосон цалингийн тооцооны картад гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

**2.2. Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05 өдрийн 347 тоот тушаалын хавсралт ” НХМаягт ЦХ-4” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |         | Үүнээс    |     |               |     |                 |     |         |         |
|-----|-------------------------------------|----------------------|---------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|---------|
|     |                                     |                      |         | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |         |
|     |                                     | Тоо                  | Дүн     | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн     |
| 1   | Шүүхийн шинжилгээний алба           | 2                    | 1.850,0 | 1         |     | 0             | 0,0 | 0               | 0,0 | 2       | 1.850.0 |

#### ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

